

Есөнзүйл сумын Засаг даргын 2022 оны
 дугаар сарын ...-ны өдрийн дугаар
 албан бичгийн хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН
 ЕСӨНЗҮЙЛ СУМАНД ХАМААРАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022.10.31

Мөнхбулаг

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг тоо баримтаар товч бичих	Байгууллагын үнэлгээ	Аймгийн ЗДТГ-ын үнэлгээ
1	2	3	4	5	6
<p>Нэг. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн аймаг, орон нутагт хамаарах 25 заалтын хүрээнд (Сум, агентлагт хамаарах) Зорилт 1. Шударга, Хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх.</p>					
1.1	1.1 Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэмшүүлэх.	1.1.1 Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх.	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 40, 42-р тогтоолын дагуу Сумын Засаг даргын А/08 дугаар захирамж, Засаг даргын Тамгын газрын А/01 дүгээр тушаалуудаар Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. 2022 оны байдлаар Албан тушаалын тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн 2 албан хаагчийг албан тушаалд томилон ажлуулж байна.	100%	
		1.1.2 Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг	Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхолын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан	100%	

		хянасан дүгнэлтийг тухай бүрд олон нийтэд ил тод болгох.	дүгнэлтийг тухай бүр байгууллагын мэдээллийн самарт болон цахим хуудсанд байршуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна		
		1.1.3 Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн баримтад хүргүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн тогтоол, дүгнэлтийг хавсаргах.	Тухайн онд 3 албан хаагчийн урьдчилсан мэдүүлгийг холбогдох дүрэм журмын дагуу бүрдүүлэн Авлигтай тэмцэх газарт хүргүүлэн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг үндэслэн төрийн албанд томилон ажиллуулж байна.	100%	
1.2	1.2 Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах, нийтийн албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх.	1.2.1 Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах	2022 онд төрийн албаны богино сургалтад 3 албан хаагч, давтан сургалтад 1 албан хаагчийг хамруулаад байна.	100%	
		1.2.2 Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.	Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг ажлын байран дээр сургах, мэдлэг боловсролыг дээшлүүлэх үүднээс 2022 оны Төрийн албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж биелэлтийг нь ханган ажиллаж байна.	100%	
		1.2.3 Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах.	Албан байгууллагын дарга, эрхлэгч болон төрийн албан хаагч нарт авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг тус бүр зохион байгуулан ажиллалаа.	100%	
1.3	1.3. Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, шинэ арга хэлбэрт шилжүүлэх,	1.3.1 Төрийн байгууллагын ёс зүйн хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх,	Засаг даргын Тамгын газрын ёс зүйн хороог 2022 онд 3 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулж үйл ажиллагааг нь идэвхжүүлэн ажиллаж байна.	100%	
		1.3.2 Төрийн байгууллагуудын дотоод хяналт шалгалтын нэгжийн	Сумын Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/120 дугаар захирамжаар албан	100%	

	дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.	үйл ажиллагааг эрчимжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих.	байгууллагуудад, Засаг даргын Тамгын газрын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/03 дугаар тушаалаар дотоодын хяналт шалгалт хийх нэгжүүдийг байгуулан 2022 оны ажлын төлөвлөгөөг баталгаажуулан биелэлтийг нь ханган ажиллаж байна.		
Зорилт 2. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангах, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх.					
2.1	2.1 Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх.	2.1.1 Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэх батлуулах.	Төрийн үйлчилгээг иргэнд E-mongolia цахим системээр 90 төрлийн лавлагаа үйлчилгээ болон бусад цахим сүлжээгээр холбогдох лавлагаа мэдээллийг хүргэн ажиллаж байна.	100%	
2.2	2.2 Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуй нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх.	2.2.1 Албан байгууллагын дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах.	Сумын Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/120 дугаар захирамжаар албан байгууллагуудад, Засаг даргын Тамгын газрын 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/03 дугаар тушаалаар дотоодын хяналт шалгалт хийх нэгжүүдийг байгуулан 2022 оны ажлын төлөвлөгөөг баталгаажуулан биелэлтийг нь ханган ажиллаж байна.	100%	
2.3	2.3 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах.	2.3.1 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх.	Сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажлын үзүүлэлтийг тухайн онд нийт 50 иргэнээс авч үр дүнг гарган албан ажилдаа санал хүсэлтийг нь тусган ажиллаж байна. Мөн орон нутгийн хөгжлийн сангаар 2023 онд хийгдэх ажлуудыг цахим болон цаасаар санал асуулга авч саналыг нэгтгэн цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тогтоогоод байна.	100%	

		2.3.2 Орон нутгийн хэмжээнд хэрэгжиж буй урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх.	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанд оруулан хэлэлцүүлж үнлэлт дүгнэлт аван ажиллаж байна.	100%	
		2.3.3 Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, хэрэгжүүлэх.	Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд хагас бүтэн жилээр үнэлж үр дүнг тооцон ажиллаж байна.	100%	
Зорилт 3. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх.					
3.1	3.1 Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэнд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх.	3.1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “Засгийн газрын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах.	Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “Засгийн газрын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд хугацаанд нь тогтмол байршуулан ажиллаж байна.	100%	
		3.1.2 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийн ил тод байдлын үнэлгээг хийж, холбогдох журам, дүрэмд өөрчлөлт оруулсан байх.	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажилуудыг холбогдох журам зааврын дагуу иргэдээс санал авч эрэмбэлэн багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн хийх ажлыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж ил тод нээлттэй цахим хаягт байршуулан ажиллаж байна.	100%	
3.2	3.2 Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах,	3.2.1 Орон нутгийн төсвийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч туснах.	Орон нутгийн төсвийн талаар, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгадаг.	100%	

	аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлага тооцох, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх	3.2.2 Орон нутгийн төсвийн төсөл санал авах хэлэлцүүлгийн талаар засгийн газрын www.iltod.mn , www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх.	Орон нутгийн төсвийн төсөл, орон нутгийн төсөв гүйцэтгэлийг засгийн газрын www.iltod.mn , www.shilendans.mn цахим хуудас болон орон нутгийн цахим хаяг бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэж ажиллаж байна.	100%	
		3.2.3 Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас төрийн (захиргааны) байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх.	Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын хувьд 2022 онд зөрчил гаргаагүй байна.	100%	
Зорилт 4. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх					
4.1	4.1 Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт хариуцлагыг дээшлүүлэх.	4.1.1 Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, цаашид тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулж хэвшүүлэх.	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан www.tender.gov.mn цахим хаяг байршуулан худалдан авах журмын дагуу цахим хэлбэрээр тендер зохион байгуулан ажиллаж байна.	100%	
		4.1.2 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсанд ажиллаж байна.	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг www.shilendans.gov.mn , www.tender.gov.mn цахим хуудсанд ажиллаж байна.	100%	
		4.1.3 Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулж мэдээлэх.	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг www.tender.gov.mn , www.shilendans.gov.mn , цахим	100%	

			хуудсанд байршуулан мэдээллэж байна.		
Зорилт 5. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх.					
5.1	5.1 Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр боловсруулж хэрэгжүүлэх.	5.1.1 Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр өрсөлдөгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд хүндэтгэлтэй хандах, ёс суртахуунтай, өрсөлдөөнт орчин бүхий бизнесийг дэмжин хөгжүүлэх.	Сумын жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2022 онд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор шинэчлэн баталж төслийг 2022 оны 10-р сарын 03-ний өдрөөс эхлэн 2022 оны 11-р сарын 03-ний өдрийн хооронд зарлаж иргэд аж ахуй нэгжүүдээс төслийг нь авч байна. Иргэдээс ирсэн төслүүдийг хууль тогтоомжийн хүрээнд эрэмбэлэн санхүүжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	100%	
Зорилт 6. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх.					
6	6.1 Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх.	6.1.1 Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлж, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх.	Суманд “Өндөргэгээний хурд” уяачдын холбоо, Ахмадын холбоо, Эмэгтэйчүүдийн холбоо, “Есөн-Өлзий” бөхийн холбоо, “Гэгээнтэний суман зурхай” шагайн холбоо гэсэн төрийн бус үйл байгууллагууд суманд үйл ажиллагаа явуулж байна. Тус төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нь тухай бүр дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна.	100%	
		6.1.2 Сум, байгууллагын түвшинд Авилагатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх жилийн төлөвлөгөө	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн Есөнзүйл суманд хамаарах арга хэмжээний 2022 хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг нь ханган	100%	

	гарган, хэрэгжүүлж, биелэлтийг хагас бүтэн жилээр тайлагнах, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд удирдлагын манлайлыг хэрэгжүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлийн тоог бууруулах, таслан зогсоох.	ажиллаж байна. Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын хувьд 2022 онд зөрчил гаргаагүй байна.		
	6.1.3 Засгийн газрын 2021 оны 109 дүгээр “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангах.	Шилэн дансны тухай хуульд заасан зарчмыг баримтлан мэдээллийг үнэн зөв, ойлгомжтой, тогтсон хугацаанд тогтмол шуурхай, нээлттэй мэдээлж, мөн МУ-ын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%	
	6.1.4 Сумын албан ёсны цахим хуудас ашиглалтыг сайжруулах, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тодорхой хөрөнгө, мөнгө шийдвэрлэн, зарцуулах.	Авлигын эсрэг хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон төлөвлөгөөний биелэлт, мэдээ мэдээллийг цахим хуудсанд байршуулан ажиллаж байна. Esunzuil.ov.gov.mn домойн нэртэй цахим хуудсанд 2022 онд 180000 төгрөгийг зарцуулан вэйб сайтыг хөтлөн хөгжүүлж байна. Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан өдөр тутмын ажил үйлчилгээг Esunzuil Zdtgazar, зар мэдээг Зар Есөнзүйл сум гэсэн фэйсбүүк гэсэн цахим хуудсуудаар иргэдэд мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.	100%	

Зорилт 7. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх.					
7	7.1 Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх.	7.1.1 Төрийн байгууллагууд Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг сайжруулах.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн Есөнзүйл суманд хамаарах арга хэмжээний 2022 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.	100%	
		7.1.2 Авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах, хамтран ажиллах.	Иргэдийн санал хүсэлт, гомдлыг цаасаар, саналын хайрцагаар, нээлттэй утсаар авч байна. Мөн Esunzuil Zdtgazap гэсэн фэйсбүүк цахим хуудсуудаар иргэдийн санал хүсэлтийн 24 цагийн турш авч байна.	100%	
ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ				100%	

Хүснэгт -2

д/д	Төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэсэн ажлын төрөл	Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг тоо баримтаар товч дурьдах
1	Сум, байгууллагын албан ёсны ямар вэб сайтад авлигын эсрэг хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, мэдээ, мэдээлэл, жилийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг байршуулсан талаар /цахим хуудасны нэр, хаяг, аль хэсгээс харах/	Авлигын эсрэг хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон төлөвлөгөөний биелэлт, мэдээ мэдээллийг esunzuil.ov.gov.mn цахим хуудсанд байршуулан ажиллаж байна. Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан өдөр тутмын ажил үйлчилгээг Esunzuil Zdtgazap, зар мэдээг Зар Есөнзүйл сум гэсэн фэйсбүүк гэсэн цахим хуудсуудаар иргэдэд мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.
2	Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гаргасан шийдвэр /тоо/	3
3	Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө	229000
4	Зохион байгуулсан цахим болон танхим сургалтын тоо	2
5	Цахим болон танхимын сургалтанд хамрагдсан удирдах албан тушаалтан, төрийн албан хаагч, иргэдийн тоо	1.Удирдах албан тушаалтны тоо-9 2.Төрийн албан хаагчийн тоо 124 3. Иргэдийн тоо-56 Нийт тоо-189
6	Авлигын хууль тогтоомжийн чиглэлээр тараасан гарын авлага, тараах материалын тоо	2

7	Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулага, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг материал г.м/	Авлигын эсрэг хууль тогтоомжийг танхим болон цахим хэлбэрээр сургалт сурталчилгааг хийж иргэдэд сурталчиллан ажиллаж байна.
8	АТҮхэтөлбөр болон Авлигын эсрэг үйл ажиллагаан жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарсан өөрчлөлт, ач холбогдол, үр дүн	Сумын хэмжээнд АТҮхэтөлбөр болон Авлигын эсрэг үйл ажиллагаан жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр 2022 онд авлига, ашиг сонирхолын зөрчил гараагүй байна.
9	Сум, байгууллагын төрийн албан хаагчдаас авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан эсэх /тоо/	Сумын хэмжээнд 2022 онд шуурхай удирдлагын төв гомдол мэдээлэл ирээгүй төдийгүй авлига, ашиг сонирхолын зөрчил гараагүй байна.
10	Авлигатай тэмцэх газраас авлига, ашиг сонирхлын зөрчил арилгах болон хариуцлага тооцохтой холбоотой ирүүлсэн албан бичиг, хариу өгсөн эсэх	Авлигатай тэмцэх газраас авлига, ашиг сонирхлын зөрчил арилгах болон хариуцлага тооцохтой холбоотой ирүүлсэн албан бичиг ирээгүй байна.

ХЯНАСАН: ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.БАТ-ӨЛЗИЙ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН: ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА С.БАТ-ЭРДЭНЭ